

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРААС
2019 ОНЫ 01 ДҮГЭЭР САРД ХЭРЭГЖҮҮЛСЭН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН


2019 оны 02 дугаар сарын 02

Улаанбаатар хот

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гадаадын болон өөрийн орны иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2019 оны 01 дүгээр сард дараахь ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

1.1. Виз, зөвшөөрөл, харьяатын чиглэлээр:



Тайлант хугацаанд “Монгол Улсад оршин суух үнэмлэх” 4224 ширхгийг шинээр хэвлэн, 1842 ширхэг үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 34 ширхэг үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийлээ. Цагаач, гэр бүлийн шалтгаанаар оршин суугч гадаадын 82 иргэнд хувийн хэрэг шинээр нээж, 195 иргэний хувийн хэрэгт баяжилт хийн нийт 277 иргэний мэдээллийг цахим архивт оруулсан байна. Мөн гадаадын 10 иргэнд регистрийн дугаар олгож, харьяалалгүй гурван хүнд зорчих үнэмлэх олгосон. Үйлчилгээний танхимд 1060 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авчээ. Визийн зөвшөөрөл, хувийн урилга олгох үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх програм хангамжийн хүрээнд 11 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүртгүүлж, есөн аж ахуйн нэгж, байгууллагын 11 гадаадын иргэний визийн зөвшөөрлийг шийдвэрлэлээ. Нийт 1927 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгснөөс 1800-1882 дугаарын утсаар 1567, биечлэн 360 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.

2019 оны 01 дүгээр сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 4.9 хувиар, виз олголт 22.1 хувиар, оршин суух зөвшөөрөл олголт 22.1 хувиар, оршин суух зөвшөөрлийн хасалт 23.6 хувиар, түр

ирэгчийн бүртгэл 3.7 хувиар, түр ирэгчийн хасалт 15.1 хувиар, визийн сунгалт 15.5 хувиар тус тус өссөн, харин хувийн урилга олголт 37.0 хувиар, оршин суух зөвшөөрөл сунгалт 15.5 хувиар тус тус буурсан байна.

Иргэний харьяалал, хүүхэд үрчлэлт, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын чиглэлээр:

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан таван улсын 28 иргэн, харьяалалгүй долоон хүний, нийт 35 хүсэлт хянагдаж байгаа бөгөөд “Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргагчтай ярилцлага хийх журам”-ын дагуу нэг улсын хоёр иргэн, харьяалалгүй дөрвөн хүнтэй ярилцлага хийлээ.

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан нэг улсын нэг иргэн, харьяалалгүй гурван хүний хүсэлтэд холбогдох байгууллагуудаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан нэг улсын дөрвөн иргэн, харьяалалгүй хүний хүсэлтийг шийдвэрлүүлэхээр Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлсэн байна.


Мөн Монгол Улсын харьяатаас гарч гадаадын таван улсын харьяат болох хүсэлт гаргасан 24 иргэний хүсэлтийг шинээр хүлээн авсан.

Монгол Улсын харьяатаас гарч гадаадын нэг улсын харьяат болох хүсэлт гаргасан 40 иргэний баримт бичгийг хянан холбогдох санал авахаар Улсын бүртгэлийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газарт, 46 иргэний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, 17 иргэний хүсэлтийг Ерөнхий сайдад танилцуулсны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барьсан байна.

Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан хоёр улсын зургаан иргэний хүсэлт хянагдаж байгаа ба хуульд заасан шалгуурыг хангаагүй 12 иргэний хүсэлтийг буцаасан.

Иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан харьяалалгүй найман хүний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

Түүнчлэн хоёрдмол харьяалал үүсгэсэн 73 иргэнийг бүртгэж мэдээллийн санд оруулсан ба нийт 3029 иргэн бүртгэлтэй байна.



Тайлант хугацаанд Мэргэжлийн зөвлөлийн хурлаар есөн төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын асуудлыг хэлэлцүүлэн хоёр байгууллагад шинээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгон, долоон байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгасан байна. Түүнчлэн дөрвөн төрийн бус байгууллагын хүсэлтийг шинээр хүлээн авсан. 2019 оны 01 дүгээр сарын байдлаар тус байгууллагад бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 96 төрийн бус байгууллага байна. Мөн гадаадын нэг улсын гэр бүлд үрчлүүлсэн гурван хүүхдийн үрчлэлтийн дараах тайланг хүлээн авч, мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

1.2. Хяналт шалгалт, албадан гаргах ажиллагааны чиглэлээр:


Тайлангийн хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн 11 улсын 56 иргэнийг байгууллагын даргын 22 удаагийн тушаалаар тус улсаас албадан гаргасан ба мэдээллийг холбогдох газруудад албан бичгээр хүргүүлэх ажлыг зохион байгуулж ажиллалаа. Мөн байгууллагын даргын тушаалаар Монгол Улсаас албадан гаргасан нэг гадаадын иргэний Монгол Улсаас албадан гаргасан тушаалыг хугацаанаас өмнө цуцалж, нэг гадаадын иргэний Монгол Улсаас албадан гаргасан хугацаанд өөрчлөлт оруулсан.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр байгууллагын даргын хоёр удаагийн тушаалаар хоёр улсын хоёр иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлж, гурван удаагийн тушаалаар гурван улсын гурван иргэний хилээр нэвтрэх эрхийг сэргээн ажиллалаа.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолд заасны дагуу 64 гадаадын иргэнийг орох чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан ба зохих бичиг баримтын бүрдэл хангаагүй 12 гадаадын иргэнийг гарах чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаажээ.

Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүгчийн 2 захирамжаар гадаадын нэг улсын хоёр иргэнийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвийн дэргэдэх гадаадын иргэнийг саатуулах байранд саатуулсан.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасан үндэслэлээр нэг улсын хоёр иргэнд гарах сануулга өгсөн ба Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг үндэслэн дөрвөн аж ахуйн нэгжид хяналтын улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн.



Тайлангийн хугацаанд зургаан удаагийн төлөвлөгөөт, 28 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 104 аж ахуйн нэгж, байгууллага, 385 гадаадын иргэнийг хамруулсан ба 184 гадаадын иргэн, 248 аж ахуйн нэгж, байгууллага /489 гадаадын иргэн/, гурван уригч иргэн /гурван гадаадын иргэн/-д Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулж, 265,440,000 /хоёр зуун жаран таван сая дөрвөн зуун дөчин мянга/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүллээ.

2019 оны 01 дүгээр сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 54.6 хувиар, зөрчил гаргасан уригч хуулийн этгээд нэг дахин, зөрчил гаргасан уригч иргэн 50.0 хувиар, албадан гаргагдсан гадаадын иргэн 5.7 хувиар тус тус өссөн, харин гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн 88.2 хувиар буурсан байна.

ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, дотоод ажлын чиглэлээр:

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/227 дугаар тушаалаар тус байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц орон тоог шинэчлэн баталсны дагуу 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс зохион байгуулалтын шинэ бүтцээр ажиллаж эхэлсэн. Байгууллагын даргын 2018 оны Б/347 дугаар тушаалаар Гадаадын иргэн, харьяатын газрын орон нутаг дахь нэгжийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн баталж, нийт албан хаагчдыг Б/364 дугаар тушаалаар албан тушаалаас нь чөлөөлж, Б/365 тушаалаар албан тушаалд томилов. Бүтэц, орон тоо шинэчлэгдсэнтэй холбогдуулан ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлах ажлын хэсгийг байгууллагын даргын 2018 оны А/436 дугаар тушаалаар байгуулж улмаар А/441 дүгээр тушаалаар нийт ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталж, байгууллагын дотоод сүлжээнд байршуулан ажиллалаа.

Эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр 2018 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, байгууллагын 2018 оны үйл ажиллагааны тайлан болон инфографик мэдээ, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/248 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан удирдамжийн дагуу Хөвсгөл, Орхон, Баянхонгор, Өвөрхангай аймгуудад ажилласан ажлын хэсгийн шалгалтын мөрөөр ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт, жендерийн эрх тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2018 онд хийсэн ажлын тайлан, албан хаагчдын хүйсийн тэнцвэрт байдлын судалгаа, жендерийн салбар зөвлөлийн 2019 онд хэрэгжүүлэх жендерийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын дагуу холбогдох хэсгийн тайланг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргад, “Хууль сахиулах салбарын инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2018 оны ажлын төлөвлөгөөний 2018 оны 4 дүгээр улирлын биелэлтийг Хууль сахиулахын их сургуулийн эрдэм шинжилгээ эрхэлсэн тэргүүн дэд захиралд, Гадаадын иргэн, харьяатын газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөний биелэлтийг Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанд тус тус албан бичгээр хүргүүлэн ажиллалаа.

Хууль зүй, дотоод хэргийн сайдтай Гадаадын иргэн, харьяатын газрын даргын байгуулсан 2018 оны үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг нэгтгэн, үнэлж Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн бөгөөд 2019 онд байгуулах үр дүнгийн гэрээний төслийг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргад албан бичгээр болон цахим шуудангаар хүргүүлсэн.

Байгууллагын 2018 оны ажлын хураангуй тайланг сэтгүүл хэлбэрээр хэвлэн харьяалах нэгж, албан хаагчдад хүргүүлсэн бөгөөд 2018 оны онцлох ажил болон үйл ажиллагааны тайланг видео хэлбэрээр бэлтгэн байгууллагын тайлангийн хурлыг зохион байгуулсан.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанаас зохион байгуулсан “Хүний амь нас хохирсон арга зам, байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах нь” хэлэлцүүлэгт 5 албан хаагч, Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтад 3 албан хаагч, Хууль зүй дотоод хэргийн яам Азийн сантай хамтран хэрэгжүүлж буй “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: Албан хаагчдыг чадавхжуулах нь” төслийн хүрээнд зохион байгуулагдсан сертификаттай сургалтад 15 албан хаагчийг тус тус хамруулах ажлыг зохион байгуулсан. Мөн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах үүрэг бүхий албан тушаалтнуудад “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргахад анхаарах асуудал” сэдвээр сургалт зохион байгууллаа.

Тайлант хугацаанд байгууллагын мэдээллийн цагаар таван удаагийн мэдээлэл, сургалт орж, давхардсан тоогоор 239 албан хаагч, дөрвөн удаагийн цахим хуралд давхардсан тоогоор 395 албан хаагч хамрагдсан байна.

Монголын Үндэсний олон нийтийн телевизийн “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлэгт хяналтын улсын ахлах байцаагч, виз зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн нар оролцож “Гадаадын иргэнд Монгол Улсын виз олгох журам, Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журмын хэрэгжилт” сэдвийн хүрээнд холбогдох мэдээллийг өгсөн бөгөөд нэвтрүүлгийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудсанд байршуулсан.

Мөн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах сэтгүүлч, сурвалжлагчдад байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааг таниулах уулзалт, сургалтыг зохион байгуулж, байгууллагын 2018 онд хийж хэрэгжүүлсэн болон 2019 онд хийгдэх төлөвлөгөөт ажлынхаа талаар мэдээлэл өгч, байгууллагын үйл ажиллагааг таниулан сурталчиллаа.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний улсын төсөвт, төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын бүтээгдэхүүн танилцуулах үзэсгэлэн, нээлттэй арга хэмжээнд хяналтын улсын байцаагчийн нэг бүрийн хэрэгсэл, алба хаагчийн дүрэмт хувцас, Монгол Улсад оршин суух үнэмлэх, визийн хуудас, зорчих үнэмлэх, байгууллагаас хэвлэсэн ном товхимол, сэтгүүл, тараах материал, үйл ажиллагаанд хэрэглэгддэг тоног төхөөрөмжүүдээр үзэсгэлэн гаргаж, иргэд, олон нийтэд танилцуулан ажиллав.

“Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, иргэд, байгууллагуудаас албан хаагчдад мэндчилгээ өгөх нэрийн дор хуулиар хориглосон бэлэг өгөх, авах зэрэг үйлдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийт албан хаагчдад мэдэгдэл хүргүүлсэн. Мөн дээрх тогтоол болон “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2017 оны нэгдүгээр албан даалгаврын хүрээнд албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах, албаны чөлөө, гадуур ажлын бүртгэлийг чанаржуулах, ажлын байранд төрсөн өдөр болон хувь хүнд хамаарах баяр ёслол тэмдэглэхийг хориглох, утаат тамхины хэрэглээг хязгаарлах, биеийн тамир, спортоор хичээллэх, дүрэмт хувцас өмсөх, хэрэглэх журмын хэрэгжилтийг сайжруулах зэрэг асуудлаар байгууллагын даргын 2019 оны 01 дүгээр албан даалгаврыг батлан, хэрэгжилтэд өдөр тутам хяналт тавин ажиллаж байна.

Төв болон орон нутаг дахь газарт нийт 88 өргөдөл ирснийг хүлээн авч, бүртгэлжүүлэн харьяалах газар, хэлтэст нь шилжүүлснээс 72 өргөдөл

шийдвэрлэгдэж, 16 өргөдөл хуульд заасан хугацааны хүрээнд шийдвэрлэлтийн шатандаа байгаа ба хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй.

Тайлант хугацаанд байгууллагын “Мэргэжлийн зөвлөл” гурван удаа, “Даргын дэргэдэх зөвлөл” хоёр удаа хуралдаж, тодорхой асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрийн биелэлтийг хангуулан ажиллалаа.

2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

Засгийн газрын 2018 оны 368 дугаар тогтоолоор тус байгууллагын төв байрыг Дотоодын цэргийн хамгаалалтад авсантай холбогдуулан Дотоодын цэргийн 05 дугаар ангийн захирагчтай хамтарсан “Гадаадын иргэн, харьяатын газрын төв байранд хүн, ачаа, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх журам”-ыг 2019 оны А/11, А/09 дугаар тушаалаар баталлаа.

Шинээр томилогдохоор нэр дэвшсэн тав, шилжин томилогдохоор нэр дэвшсэн 27, дэвшин томилогдохоор нэр дэвшсэн хоёр, нийт 34 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авч Авлигатай тэмцэх газарт хянуулахаар хүргүүлэв.

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Консул Кил Кан Муг, Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яамны Консул Жейсон П.Спэлбэр, Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны хоёрдугаар нарийн бичгийн дарга С.Заяа, Нэгдсэн үндэстний байгууллагын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын Монгол дахь салбар хариуцсан төлөөлөгч Р.Оюунбилэг, Бүгд Найрамдах Турк Улсын “ТИКА” байгууллагын Улаанбаатар дахь хөтөлбөр зохицуулалтын газарт шинээр томилогдсон хөтөлбөрийн ерөнхий зохицуулагч ноён Емрах Устамор, Бүгд Найрамдах Солонгос Улсын “КОЙКА” байгууллагын Монгол дахь Төлөөлөгчийн газарт шинээр томилогдсон суурин төлөөлөгч Жу Хэйн Нантай тус тус албан уулзалтыг зохион байгуулсан нь 2018 оны хамтын ажиллагааг дүгнэж, 2019 онд хэрэгжүүлэх ажлаа төлөвлөж, хэлэлцсэн үр дүнтэй арга хэмжээ боллоо.

Мөн Өмнөд бүс дэх газрын дарга, Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн дарга нар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөх хотод Нийгмийг аюулаас хамгаалах тэнхимийн Хилээр орох гарах асуудал хариуцсан товчооны төлөөлөгчидтэй хийх ажил хэргийн уулзалт, Мэдээллийн технологийн хэлтсийн ерөнхий инженерийг Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Техник, Эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд Сүлжээний аюулгүй байдлын сертификаттай сургалтад хамруулах ажлыг тус тус зохион байгуулан ажиллалаа.

2.3. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Зорчигчийн урьдчилсан мэдээллийн дэвшилтэд систем “APP”-ийг Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч, тээврийн хэрэгсэл, гадаадын иргэний бүртгэл, хяналтын нэгдсэн систем “ISM”-тэй холбох бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд шаардлагатай байгаа тоног төхөөрөмж, програм хангамжийн судалгааг гарган албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн албан бичгийн дагуу “Женералтеч” ХХК-тай 248.5 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, програм хангамжийг худалдан авах тухай гэрээ байгуулж, 3 ширхэг сервер холбогдох эрх, лицензүүдийг хүлээн аваад байна.

Мөн албаны үйл ажиллагааг хэвийн явуулах, төрийн үйлчилгээг иргэд, үйлчлүүлэгчдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор “Эс Ай Си Ти” ХХК-тай ажил

гүйцэтгэх гэрээ байгуулан 18 аймгийн төвүүдийг холбосон сүлжээний хурдыг 3 дахин нэмэгдүүллээ.

2.4. Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн чиглэлээр:

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны 2018 оны танилцуулах тойм мэдээ, олон улсын болон гадаадын улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын 2018 оны дөрөвдүгээр улирлын танилцуулах тойм мэдээг Үндэсний аюулгүй байдлын ажлын албанд, байгууллагын 2018 оны статистик тоон мэдээг Хууль зүй, дотоод хэргийн яам, Үндэсний статистикийн хороонд тус тус хүргүүлсэн.

Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтсээс бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын чиг үүргийн үзүүлэлт, байгууллагын нээлттэй байдал, байгууллагын дотоодод чиглэсэн үйл ажиллагаанд нийт 13 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээг хийн тайланг нэгтгэж, холбогдох байгууллагад тухай бүр хүргүүлэн ажиллалаа. Тухайлбал: Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд үнэлгээ өгч байгууллагын “Даргын дэргэдэх зөвлөл”-ийн 2018 оны 11 дүгээр хурлаар хэлэлцүүлэн Хууль зүй, дотоод хэргийн яаманд албан бичгээр хүргүүллээ. Мөн Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт буюу төсвийн төвлөрүүлэн захирагчийн үр дүнгийн гэрээний биелэлт, Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт, байгууллагын ил тод байдлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Түүнчлэн “Эрдэм судлал, судалгааны хүрээлэн” төрийн бус байгууллагаас тус байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээг хийж, тайлан, есөн заалт бүхий зөвлөмж гарган ирүүлсэн.

Байгууллагын хэвийн үйл ажиллагааг явуулахад учирч болох эрсдэлийн судалгаа, 2018 оны Эрсдэлийн үнэлгээний тайлан, дотоод аудитын 2018 оны тайлан, Үндэсний аудитын газраас Гадаадын иргэн, харьяатын газрын 2017 оны санхүүгийн тайланд аудитын шалгалтаар илэрсэн зөрчлийн гүйцэтгэлийн товчоо, өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2018 оны тайланг батлагдсан маягтын дагуу гарган Хууль зүй, дотоод хэргийн яаманд албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Мөн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор төв болон орон нутаг дахь нэгжүүдийн цахим хуудас дахь тус хуулийн хэрэгжилт болон түүнийг сайжруулах, хуулийн хугацаанд мэдээ, тайланг үнэн зөв, иж бүрэн байршиж байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор байгууллагын даргын 2019 оны 01 дүгээр удирдамжийн дагуу нийцлийн аудитын шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Тус хуулийн хэрэгжилт 2018 оны дөрөвдүгээр улиралд өссөн дүнгээр 99.6 хувьтай байна.

2019 оны нэгдүгээр улиралд хилийн боомтод ажиллах хуваарийн баталж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Өмнөговь аймгийн Цагаандэл уул боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, зургийн даалгаврыг “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төслийн зохицуулагчид, мөн Замын-Үүд чөлөөт бүсийг байнгын ажиллагаанд оруулахтай холбогдуулан гэрээний төсөлд тусгах саналыг Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албанд тус тус нэгтгэн хүргүүллээ.

2.5. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын багцад Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу 2019 оны 01 дүгээр сард 487.3 сая төгрөгийн санхүүжилт олгогдсоноос 249.0 сая төгрөгийг зохих дүрэм, журмын дагуу анхан шатны баримтыг үндэслэн зарцуулсан болно.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Засгийн газрын 2003 оны 172 дугаар тогтоолын дагуу 2018 оны 01 дүгээр сарын байдлаар 285,3 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлого, 70.1 сая төгрөгийн хүү торгуулийн орлого, 15,4 сая төгрөгийн визийн хуудасны орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна.

Байгууллагын даргын 2019 оны А/01 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооноос шатахуун нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг шалгаруулалтыг цахимаар зарлан явууллаа.

Мөн авто машины парк шинэчлэх ажлын хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар гадаадын иргэний хяналт шалгалт явуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Баян-Өлгий аймаг дахь хэлтэс, Говь-Алтай аймгийн төлөөллийг туулах чадвар сайтай авто машинаар хангалаа.

2019 онд хийх бүтээн байгуулалтын хүрээнд байгууллагын хурлын танхимыг өргөтгөх, байгууллагын түүхийг харуулсан үзмэр бүхий музейн өрөө байгуулахад гарах зардлын тооцоог гарган төсвийг баталж, албан хаагчдын дотоод нөөц бололцоог дайчлан засварын ажлыг эхлүүлээд байна.

2.6. Хилийн боомт, орон нутгийн чиглэлээр:

Хөшигийн хөндийн олон улсын шинэ нисэх буудал 2019 оны 07 дугаар сард ашиглалтад орж Агаарын замын боомт хариуцсан газар шилжин нүүхтэй холбогдуулан Төв аймгийн Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга, Хууль зүйн хэлтсийн дарга, Төрийн сангийн хэлтсийн даргатай 2019 онд хамтран ажиллах талаар Санхүү, хангалт, үйлчилгээний газрын дарга, Агаарын замын боомт хариуцсан газрын дарга, тус газрын ахлах нягтлан бодогч, Төв аймаг дахь ахлах мэргэжилтэн нар ажлын уулзалт зохион байгуулж ажиллав.

Дорноговь аймаг дахь газрын Сайншанд дахь мэргэжилтэн Дорноговь аймаг дахь цагдаагийн газрын 40 албан хаагчдад байгууллагын чиг үүрэг, Дорноговь аймаг дахь газрын бүтэц, үйл ажиллагааны талаар товч танилцуулж, гадаадын иргэдийн паспорт, визийн ангилал, хугацааны талаар, тус газрын виз, зөвшөөрлийн мэргэжилтэн Хилийн 0108 дугаар ангийн Замын-Үүд авто замын боомтод үүрэг гүйцэтгэж буй 16 албан хаагчдад “Монгол Улсын виз олгох журам”, “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам”-ын талаар сургалт, мэдээллийг зохион байгууллаа.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Нэгдсэн үндэстний байгууллагын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газраас хамтран Хэнтий аймагт зохион байгуулагдсан “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн хэрэгжилт, төсөл” сэдэвт зөвлөгөөнд Зүүн бүс дэх газрын Хэнтий аймгийн ахлах мэргэжилтэн, Сүхбаатар аймаг дахь мэргэжилтэн, Дорнод аймаг дахь хилийн цэргийн 0132 дугаар ангиас зохион байгуулсан “Харилцан ажиллагаатай байгууллагуудын хамтын ажиллагаа”-ны уулзалтад тус газрын Захиргааны ахлах мэргэжилтэн тус тус оролцсон.

Мөн Өмнөговь аймаг, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Баяннуур хотын хооронд 2019 оны хамтран ажиллах

төлөвлөгөөг хэлэлцэх зорилгоор Өмнөговь аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг Баяннуур хотын Ганцмод хотод ажилласан бөгөөд уг ажлын хэсэгт Өмнөд бүс дэх газрын дарга орж ажиллалаа.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР